# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

**Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар**

**2025 оны III улирал**

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Хасах саналтай эсэх | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | | |
| 17 | 38 | Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-04-05 Дугаар 2016 №10 НББСШУБХ | 3.1/. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, хязгаарлах тухай эрсдлийн удирдлагын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, (2018-2020 оны сүрьеэ, бэлгийн замын халдварт өвчний статистик иргүүлэх) | -18 газарт 1907 сүрьеэгийн эрсдэлт бүлгийн хүн амд үзлэг, шинжилгээ хийгдсэнээс 6 сүрьеэг илрүүлэн 100% эмчилгээ, хяналтанд авсан.<br>3 сум, 5 өэмт-н нийт 5639 эрсдэлт бүлгийн судалгааг гарган 1907 сүрьеэгийн эрсдэлт бүлгийн хүн амд үзлэг, шинжилгээ хийгдсэнээс 6 сүрьеэг илрүүлэн 100% эмчилгээ, хяналтанд авсан.<br>ХӨСҮТ-д сүрьеэгийн эрсдэлт бүлэг 3 сум, 4 өрхийн нийт 5639 хүний судалгааг гарган илгээсэн.<br>Сүрьеэ далд халдварын эмчилгээнд-27<br>2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтран ажиллах сүрьеэгийн шинэ эмчилгээний талаар сургалт, мэдээлэл хийсэн.<br>ЕБС, СӨББ, их, дээд болон коллежийн 56 эмч мэргэжилтэнд сургалт зохион байгуулсан.<br>ХӨСҮТ-ээс ирсэн<br>“Сүрьеэгийн өвчний сүүлийн үеийн оношилгоо, эмчилгээ, ялган оношлогоо сэдэвт сургалт” 30 эмч мэргэжилтэнд<br>НЭ-ийн Сүрьеэгийн эмч нар сүүлийн эмчилгээ, эмчийн хожимдол сэдвээр II -р шатлалын 38 эмч мэргэжилтэнд сургалт хийсэн.<br>Олон нийтэд чигэлсэн сургалт мэдээлэл, сурталчилгаа<br>1. **Танхимаар:**<br>• 18-р сургуулийн ахлах бүлэг, Уул уурхайн коллежийн 1,2-р курсын 158 оюутнууд болон аж ахуйн нэгж албан байгууллагын ажилтан албан хаагчид, АШЭМБ(3 сум, 5 өрх)-уудыг хамруулан сүрьеэтэй тэмцэх өдрөөр төлөвлөгөө гарган нийт 19 удаагийн давтамжаар нийт 1581 иргэдэд танхимаар сургалт зохион байгуулсан.<br>2. **Цахимаар:**<br>• Дархан татах хэсэг ДЕПО-ийн 325 ажилтан<br>3. **Уралдаан тэмцээн, өдөрлөг аян хэлбрээр**<br>• 18-р сургуулийн ахлах бүлгийн сурагчдын дунд ЭССЭ бичлэгийн уралдаан зарлан 11 материал ирж 3-ыг шалгаруулан урамшуулсан.<br>• Уул уурхайн коллежийн 1,2-р ангийн оюутнуудын дунд 3 салбараас 2,2 нийт 6 баг бүрдүүлэн дэвжээ тэмцээн зохион байгуулж 3 байр эзлүүлэн шагнал гардууллаа.<br>• АШЭМБ(3 сум, 5 өрх)-ууд сүрьеэтэй тэмцэх өдрөөр томоохон зах, худалдааны төвүүдэд, НЭ-н тасаг амбулаторууд тухайн нэгждээ өдөрлөг хийн нийт 4800 иргэдэд тараах материал болон дархлаа дэмжих бэлдмэлүүд өгсөн. | 95% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ХӨСҮТ-ээс ирсэн “Сүрьеэгийн оношилгоо эмчилгээнд анхаарах асуудал”-нд 20 эмч мэргэжилтэн хийсэн.<br><br>2025 оны 3 дугаар улиралд БЗДХ ХДХВ, ДОХ-ын Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд нийт 6161 иргэнийг хамруулсан. Үүнээс:<br>1.Жирэмсэн эмэгтэйчүүд-1231<br>2.Оюутан залуучууд- 1240<br>3.Албан хаагч ажилтан- 803<br>4.ЭБҮ,ЭБЭ-157<br>5.Эрсдэл бүлгийн – 218<br>6.Хүчний байгууллага-274<br>7.ШШГГазар 345-р анги/ хоригдол/-51<br>8.Оюутан цэрэг -131<br>9.Жолооч,нар аргаар алт олборлогч,хөдөлгөөнт хүн ам-208<br>10.Эрт илрүүлэгээр -1613<br>11.2025 оны 1-р ээлжийн цэргийн жинхэнэ албанд татагдаж буй цэргийн насны 18-25 насны залуучууд тэнцсэн-150<br>12.Орон гэргүй иргэд “Жаргалтай амьдрал” төвийн-85/давтан/<br>Үр дүн: БЗДХ ХДХВ, ДОХ-ын идэвхитэй тандалт эрт илрүүлгийн үйл ажиллагаа 38%-иар нэмэгдсэн байна.<br>БЗДХ.ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх сургалтын материалыг 4 төрлийн 2000 ширхэгийг олшруулан тарааж түгээж олон нийтийн сүлжээ цахим сургалт мэдээ мэдээлэлийг нийт 20 удаагийн давтамжтай түгээсэн.<br>**Үр дүн :** Нийт -64 удаа 5624 иргэдийг сургалт сурталчилгаанд хамруулан мэдлэг хандлага 35%-иар нэмэгдсэн./сургалтын өмнөх,дараах сонжвороор мэдлэгийн түвшинг үнэлж гаргасан/.<br>Мэдээлэл түгээх нөлөөллийн арга хэмжээг Төрийн бус 2 байгуулага,ААН байгуулага,ЕБС,Их дээд сургууль,коллежийн эмч багш нийгмийн ажилтан,иргэд,ҮТСБ үе тэнгийн сургагч оюутан залуучуудтай хамтран тогтмол зохион байгуулж нийт зорилтот болон эрсдэлт бүлгийн 63% ийг хамруулсан.<br> | 65% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | <br> | | | |
| 18 | 39 | Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний | 2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан | 2025 оны 3 дугаар улирлын байдлаар БЗДХ ХДХВ, ДОХ-ын Урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд нийт 6980 иргэнийг хамруулсан. | 73% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ | аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах; | Үр дүн: БЗДХ ХДХВ, ДОХ-ын идэвхитэй тандалт эрт илрүүлгийн үйл ажиллагаа 38%-иар нэмэгдсэн байна.1.Дархан-Уул аймгийн хэмжээнд ХДХВ/ДОХ-ын халдвартай /** / кодтой иргэний /100%/ хувь нууцлалтай хяналтанд эмчлэгдэж байна. Үүнээс: Хөдөлмөрийн чадвар алдалтыг 9 иргэнд тогтоолгож хяналтын тасралтгүй байдлыг ханган ажиллаж байна. Сэтгэл засал эмчилгээнд 5 хяналтын иргэнийг сэтгэл засалч эмчээр зөвөлгөө зөвлөмжинд хамруулсан.<br>2. ХДХВ Ретровирүсийн эсрэг эмчилгээ, дагалдах халдварын эсрэг, дархлаа дэмжих, өртөлтийн өмнөх болон дараах сэргийлэлтийн эм,тариа, урвалж, оношлуур, эм бэлдмэлийг нэгдсэн байдлаар ХӨСҮТ-өөс төлөвлөгөөний дагуу ханган нийлүүлж нууцлал болон эрсдэлийн зэргийг тооцон ажиллаж байна.<br>3. Глобаль сангийн 2025 оны 3 дугаар улиралын БЗДХ/ДОХ-ын хөтөлбөр хариуцсан мэргэжилтэнүүдийн хяналт үнэлгээ/ 2025-05-26/ хийгдэж зөвлөмж өгсөн.<br>Үр дүн: Халдвартай иргэдийн сэтгэл ханамж 100% Ретровирусын эмчилгээний хяналт 100%,CD-4 эсийн хяналт-100%<br>4.2025 онд 2 удаа нийт 32 эмч ,эм зүйч,арга зүйч,сувилагчийг сургалтанд хамруулж мэдлэг хандлагыг 25%-иар нэмэгдүүлсэн. Эмч нарын тангараг сэргээх үйл ажиллагаанд 2025 оны 3-р сарын 28 нд ХДХВ/ДОХ-ын 6 эмч мэргэжилтэнг хамруулсан.<br>Үр дүн: Нууцын зэрэглэл 100% ЭБҮ шинжилгээ,үйлчилгээ,зуучлан хамруулах бүртгэлжүүлэх ажил эрчимжсэн.<br>1. Глобаль сан, ХӨСҮТ-ийн БЗДХ/ДОХ-ын тандалт судалгааны алба, “Залуус эрүүл мэнд” ТТБ, Төгс бүсгүйчүүд ТТБ-тай хамтран нийт 75 ЭБЭ,ЭБҮ-г Onlain сургалтанд 5 удаа үйл ажилллагааны талаар нууцлалын зэрэглэлтэй хамруулсан,сар бүр 2-4 ЭБЭ-ийг шинжилгээнд хамруулж үйл ажиллагаа тогтмолжсон.Сургалтын өмнөх дараах сонжвороор Мэдлэг хандлага 15% нэмэгдсэн.<br>Цөөнх олон нийтэд чиглэсэн ХДХВ,БЗДХ-аас сэргийлэх цогц үйл ажиллагааг “Залуус эрүүл мэнд” ТББ-тай хамтран 2 удаа зохион байгуулж 6 иргэнийг хамруулсан. Олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Үр дүн: Цөөнх олон нийтийн хэрэгцээнд тулгуурласан шаардлагатай тусламж, үйлчилгээнд хамруулдаг болсон.<br>1 Хүрч очих ажилтан-1, 5 Үе тэнгийнхэнээрээ дамжуулан шинэлэг арга, аргачлал ашиглан ЭБЭ-ийн халдвар илрүүлэх шинжилгээ, үйлчилгээнд зуучилан 36 ЭБЭ хамруулсан.<br>Үр дүн: Шинэлэг хэлбэрээр тогтмол зохион байгуулсанаар цөөнх шинэ олон нийтийг бүртгэлжүүлж хэвшсэн.<br>Үр дүн: БЗДХ ХДХВ, ДОХ-ын идэвхитэй тандалт эрт илрүүлгийн үйл ажиллагааг төлөвлөгөөнд тусгасаны дагуу явагдаж байна.<br>Хорих ангийн эмч, сэтгэл зүйчтэй хамтран ШШГА Нээлттэй 445-р анги, ШШГА 345-р хаалттай хорих ангийн нийт 78 ажилтан албан хаагчдад 2 удаагийн танхим,1 удаа onlain сургалтыг хийсэн. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 120 ширхэгийг зөвлөмж сурталчилгааны материалыг тараасан. Хоригдол-25 иргэнийг БЗДХ,ХДХВ-ийн халдвар илрүүлэх, оношлох шинжилгээнд хамруулахад шинэ өвчлөл илрээгүй,<br>Үр дүн: Сурталчилгааний материалаар бүрэн хангагдсан.<br>Мэдлэг хандлага 25%-иар нэмэгдсэн. Сургалт тогтмолжсон.<br>Залуус эрүүл мэнд” ТТБ-тай хамтран нийт 12 /15%/ ЭБЭ-г Onlain сургалтанд 2 удаа үйл ажилллагааны талаар нууцлалын зэрэглэлтэй хамруууллаа. 2025 онд 1.ЭБЭ, Трансжендэр олон нийтийг сайн дурын зөвлөлгөө, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг нийт 1 удаа зохион байгуулж 12 ЭБЭ хамруулсан. Сургалтын өмнөх дараах сонжвороор Мэдлэг хандлага 15% нэмэгдсэн.<br>Үр дүн: Сургалтын өмнөх дараах сонжвороор Мэдлэг хандлага 35% нэмэгдэж үйл ажиллагаа тогтмолжсон. | | | |
| | 40 | | 2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих. | Эрүүл мэндийн газрын 1 давхар буюу амбулаторийн коридорийн засвар хийгдсэн. | 100 | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |
| 39 | 84 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай<br>2022-07-11<br>Дугаар 2022_159 | 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай. | ✓ Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залсан байдаг. Эзэн Богд Чингис хааны суу алдар, өв соёл” сэдэвт лекц, сургалт зохион байгуулсан. Нийт 30 ажилтан хамрагдсан<br>✓ Эмнэлгийн орчинд Чингис хааны эш сургаал бүхий самбар байршуулж, иргэдэд сурталчилгаа хийсэн. | 85% | хасах | |
| | 85 | | 4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв ээе сахин бататгаж, улс | | 85% | хасах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай. | | | | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | |
| 61 | 119 | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай 2023-08-30 Дугаар 2023_321 | 2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх 2024-2027 онуудад хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2023 оны 08 дугаар сарын 30-ний өдрийн 321 дугаар тогтоолоор батлаж, салбар дундын уялдаа холбоог хангахад ЭМЯ БШУЯ, БХЯ, ХНХЯ болон Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хороо зэрэг байгууллагуудыг хамтран ажиллах төлөвлөгөө баталсан. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд 2025 онд Дархан-Уул аймагт хэрэгжүүлэх 5 зорилт бүхий 27 чиглэлийн арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Орон нутагт тус арга хэмжээний хэргэжилтийг сайжруулах хамтрагч байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Аймгийн НБХ-т зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах саналыг тавьсан./хүлээгдэж байна/. Эрүүл мэндийн боловсролын суурь мэдлэгийн түвшинг үнэлэх судалгааны асуумжийг Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 41, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг дадал, хандлага үнэлэх 12 нийт 53 асуулт боловсруулан цахим хэлбэрээр иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын ажилтан албан хаагчдыг судалгаанд хамруулж, байна.<br><br>2025 оны 03 дугаар улирлын байдлаар Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээнүүдийн хүрээнд 5 өрх 3 сумын эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналтыг зохион байгуулсан. Хяналт үнэлгээний үр дүнд тулгуурлан Өрх сумын арга хэмжээ хариуцсан эмч, Нийгмийн ажилтнуудад зөвлөмж боловсруулан, хяналтын нэгтгэсэн дүнг танилцуулж, өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хэрхэн идэвхжүүлэх, тулгамдаж байгаа асуудлуудын талаар нээлттэй уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус үйл ажиллагаанд нийт 15 эмч, мэргэжилтнүүд оролцсон.<br><br>Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвийн НЭМ-ийн арга хэмжээ хариуцсан эмч, НЭМА нарын мэдлэг, ур чадварыг сайжруулах, харилцан туршлага солилцох сайн туршлагыг нутагшуулах, байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор Дархан-Уул аймгийн НЭ, Өрхийн | 90% | тийм | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эмнэлэг, сумын ЭМТ-ийн НЭМ-ийн арга хэмжээ хариуцсан эмч, НЭМА нарын төлөөлөл тус бүр 1-с доошгүй хүн хамруулан Орхон аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эмнэлэг, НЭМГ, бусад холбогдох байгууллагууд харилцан туршлага солилцох аялалыг зохион байгуулсан.<br><br>21 Эрүүл мэндийг дэмжигч байгууллагуудаар туг, дэвтэр аялан 97 удаагийн сургалт зохион байгуулагдаж, 6 удаа 416 ажилтан албан хаагчдыг хамруулан урьдчилан сэргийлэх үзлэг хийгдсэн байна.<br><br>Монгол Улсын засгийн газраас Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй 14 арга хэмжээний хүрээнд нийт 67 аж ахуй нэгж, байгууллагын 3457 ажилтан албан хаагчдад, 12 ЕБС, 16 СӨБ, 4 их дээд сургуулийн оюутан залууст 214 удаагийн сургалтаар 10724 хамруулан эрүүл мэндийн боловсрол тус тус олгосон байна.<br><br>Төвийн бүсийн Дархан телевиз, RGB телевиз, Цэц.мн сайтуудтай хамтран ажиллах гэрээний хүрээнд эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөмж, ярилцлагуудыг зохион байгуулж олон нийтэд хүргэж байна. 2025 онд орон нутгийн Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран Эрүүл мэндийн газраас зохион байгуулж буй үйл ажиллагааны 61 мэдээ, 12 видео зөвлөмж, 6 контент бэлтгэн иргэд олон нийтэд хүргэсэн байна. | | | |
| 62 | 120 | “Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 2023-08-30 Дугаар 2023_322 | 2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуульд өдөр бүр “Шүд угаах цаг”-ийг бий болгон хэвшүүлж, эрүүл ахуйн шаардлага хангасан шүдээ угаах хэсэг бий болгох ажлыг үе шаттайгаар улс, орон нутгийн төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, | 2024.01.19-ны өдрийн “Эрүүл шүд арга хэмжээний төлөвлөгөө” А/27, А/25 дугаар тушаалыг хэрэгжүүлэхээр орон нутгийн онцлогт тохируулж 6 зорилт 27 арга хэмжээ төлөвлөн, хэрэгжилт 72%-тай байна.<br><br>- **Дархан-Уул аймагт ЕБС-ийн 1 дүгээр ангийн суралцагчдын** дундах урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулах ажлын хүрээнд 18-н Хувийн хэвшлийн шүдний эмнэлэг, 5-ӨЭМТ, 3-СЭМТ, 18-ЕБС-тай гэрээ байгуулан Нэгдүгээр ангийн нийт 2544 хүүхдийг 2 үе шаттай урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх үзлэгт хамруулж ажиллаа. Улсын хэмжээнд 38.719 суралцагчдаас 33.206 (85.8%) суралцагч шүдний эмгэг илрүүлэх үзлэгт хамрагдаж. Үүнээс Дархан-Уул аймагт нийт 2603 суралцагчдыг хамруулхаас 2544 сурагчид хамрагдаж нийт хамрагдалт 97.7% байна. Дархан-Уул аймагт шүдний цооролттой 6 настай хүүхдийн тоо 2544 суралцагчдын 2201 суралцагч буюу 86.5%-ийг эзэлж байна. Шүдний гажигтай хүүхдийн тоо 654 буюу 26%-ийг тус тус эзэлж байна. Урьдчилан сэргийлэх үзлэгийн үр дүнд эмчлүүлсэн суралцагчид 1843 буюу 72.4%-ийг эзэлж байна. Улсын хэмжээнд Шүдээ бүрэн угаадаггүй хүүхдийн тоо 26.453 (68.3%)-г эзэлж байна. | 80% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Дархан-Уул аймагт шүдний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан нийт 2544 суралцагчдаас шүдээ бүрэн угаадаггүй 2060 (81%) суралцагч байна<br>- Үзлэгээр илрүүлсэн **Шүдний гажигтай** 654 хүүхдийг эрүүлжүүлэх ажлыг Дархан Нэгдсэн эмнэлгийн шүдний кабинеттай хамтран зохион байгуулахаар төлөвлөж, суралцагчдын дэлгэрэнгүй судалгаа, үзлэгт хамрагдах хуваарийг боловсруулсан.<br>- Дархан-Уул аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын **“Хараа хяналт-2025-I”** арга хэмжээний дагуу 2025.05.05-аас 2025.06.26-ны өдрүүдэд 44 хүүхдэд Дархан нэгдсэн эмнэлэгт амны хөндийн үзлэг, оношилгоо, эмчилгээ хийгдсэн. Үзлэгийн үр дүнгээр:<br>- Гүн цоорол - 28<br>- Дунд цоорол - 7<br>- Өнгөц цоорол - 3<br>- Сувгийн эмчилгээ - 6<br><br>Бүрэн эрүүлжүүлсэн – 5 хүүхэд байлаа. | | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 124 | 207 | 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42 | ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд | 2022 оны 05 сарын 01-ний өдрөөс 2025 оны 09 сарын 12-ны өдрийн байдлаар Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт аймгийн хэмжээнд хамрагдвал зохих 104969 хүнээс **57001 хүн хамрагдаж 54.9%-тай байна**. Үүнээс хүүхдийн үзлэгийг авч үзвэл: 0-5 нас, 6-17 насны хүүхдийн эрт илрүүлэгт хамрагдвал зохих 38083 хүнээс 32405 хүн хамрагдаж, хамрагдалт 85,1%-тай байна. Насанд хүрэгчдийн 18+ дээш насны 65857хүн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдахаас 24596 хүн хамрагдаж, хамрагдалт 37.3%-тай байна.<br>**18+ насны эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдээс илэрсэн өвчлөл**:<br><br>-Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг-5242 буюу 21.8%<br>-Бөөр-шээс дамжуулах тогтолцооны эмгэг-2844 буюу 11.8%<br>-Зүрх судасны тогтолцооны эмгэг-2338 буюу 9.7%<br>Дотоод шүүрлийн эмгэг - 3784 буюу 15.7%<br>-Амьсгалын эрхтэн тогтолцооны эмгэг-362 буюу 1.5%<br>-Халдварт өвчин-639 буюу 2.6%<br>• Сүрьеэ сэжигтэй- 30<br>• Тэмбүү – 50<br>• Элэгний В,С вирус – 626<br>-Хавдрын сэжигтэй тохиолдол- 82 буюу 0.4%Хавдрын баттай тохиолдол-30 буюу 0.1%<br>• Умайн хүзүүний өмөн-8 | 80% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав. | • Элэгний өмөн-10<br>• Ходоодны өмөн-9<br>• Хөхний өмөн - 3<br>-Ходоод-улаан хоолойн хорт хавдарын урьдал эмгэг-250<br>-Цусны тогтолцооны эмгэг - 330<br>• Цус багадалт-282<br>• Бусад-47<br>-Элэгний хатуурал- 230<br>**0-17 насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгээс илэрсэн өвчлөл**<br>-Шүдний өвлөл – 7772 буюу 25.4%<br>-Нүдний эмгэг -582 буюу 1.9%<br>-Гүйлсэн булчирхайн эмгэг -569 буюу 1.8%<br>-Амьсгалын тогтолцоо – 259 буюу 1.0%<br>-Цус багадалт – 129 буюу 0.4%<br>-Арьс харшил – 78 буюу 0.2%<br>-Бөөр-шээс дамжуулах тогтолцооны эмгэг-56 буюу 0.2%<br>-Бага жин - 61 буюу 1.0%<br>-Бөөр давсагний үрэвсэл – 56<br>-Чихний үрэвсэл – 60<br>-Даралт ихсэлт – 38<br>-Пимоз -26<br>-Сэтгэцийн өөрчлөлт – 11<br>-Хоол боловсруулах – 10<br>-Зүрх судас – 13<br>-Вит-д дутагдал – 8<br>-Аутизим – 4 | | | |
| 130 | 214 | 2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11 | XII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1.Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийг дэмжих төвд 3ш ходоодны уян дурангийн аппарат хэвийн ажиллаж байна. 2022 оны 6-р сард 2ш ходоодны дуранг авч хэрэглээнд нэвтрүүлсэн. 2023 оны 12 сард ЭМЯ-с багц 7 төслийн хүрээнд Медимпекс ХХК Olympus medical systems компаны Evis Exera III маркын ходоодны дуран ирүүлсэн. 2022 онд ходоодны уян дурангын үзлэгт нийт-781 хүн хамрагдсан. 2023 онд нийт-2349 хүн хамрагдсан. 2025 оны IX -сарын байдлаар Нэгдсэн эмнэлгийн Эрүүл мэндийг дэмжих төвд Ходоодны уян дуранд 4838 хүн, хамрагдаад байна . | 70% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | | |
| 163 | 259 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэл 2025-04-23 Дугаар 2025_19 | 19.24.5.2.. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав | • Улаанбурхан өвчний батлагдсан 152 тохиолдол бүртгэгдсэн. Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын 681 хүний тандалт судалгааг хийж голомтын дархлаажуулалтад хамрагдвал зохих 396 хүнийг вакцинжуулсан.<br>• Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 24 ны А/249 дугаар тушаал /Эрүүл мэндийн байгууллагуудыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай/-ыг үндэслэн Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 06 сарын 26-ны өдрийн А/84 тоот тушаалын дагуу 2025.06.26-2025.07.10-ны өдрийг хүртэл өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлж товлолын болон нөхөн дархлаажуулалт, дархлаажуулалтын цахим программын шивэлт, хаалганаас хаалганд вакцинжуулалт хийх байнгын 9 цэг, явуулын 9 томилон ажиллуулж товлолын болон нөхөн дархлаажуулалт, дархлаажуулалтын эргэмж шивэлт, 0-15 настай хүүхдийн дархлаажуулалтын мэдээлэлд тулгалт хийж ажиллаж байна. ЭМГ-аас хариуцлагатай жижүүр томилон өрх, сумын дархлаажуулалтын үйл ажиллагаанд хяналт тавьсан.<br>• Улсын хэмжээнд нэгэн зэрэг зохион байгуулагдсан Улаанбурхан өвчний дархлаажуулалтыг эрчимжүүлэх **“Хаалганаас хаалганд”** хүрээнд дархлаажуулалтыг эрчимжүүлэх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэж цахим программд хүүхдүүдийн вакцины мэдээллийг шивж оруулсан.<br>  ○ Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд 5 өрх, 3 сумын эрүүл мэндийн төвүүд:<br>  ○ Дархлаажуулалтын цахим программд 6452 хүүхдийн вакцинжуулалтад хамрагдсан боловч цахимд ороогүй мэдээллийг эргэмжээр шивж оруулсан.<br>  ○ 6-8 сартай хүүхдийн улаанбурханы эсрэг вакцинд 175 хүүхэд,<br>  ○ Нөхөн дархлаажуулалтад 2310 хүүхдийг хамруулсан. | 95% | Тийм | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Өнөржүүлсэн бэлэн байдал зарлах үед нөхөн дархлаажуулалтын хамралт 17.5% байсан. 2025.09.12-ний өдрийн байдлаар хамралт 72% болсон буюу **54.5%-иар нэмэгдүүлсэн** байна. | | | |
| 166 | 262 | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-06-04 Дугаар 2025_26 | 26.27.6.2.. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх, үндэсний товлолын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн бүх шатлалын байгууллагад дэмжлэг үзүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | • 2025 оны 07 сарын 01 ны өдрийн АЗДТГ болсон удирдах ажилтны шуурхай хуралдаанд Дархан-уул аймгийн “Улаан бурхан өвчний өнөөгийн байдал,авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ,тулгамдаж байгаа асуудал” сэдвээр танилцуулгыг ЭМГ дарга хийж ажилласан байна.<br>• Дархан-Уул аймгийн хэмжээнд дархлаажуулалтыг идвэхжүүлэх “Хаалганаас хаалганд” аяны хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны талаар 2027 оны 06 сарын 30-ны өдөр хэвлэлийн бага хурал хийж, хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан иргэдэд мэдээлэл өгсөн.<br>Улсын хэмжээнд нэгэн зэрэг зохион байгуулагдсан Улаанбурхан өвчний дархлаажуулалтыг эрчимжүүлэх **“Хаалганаас хаалганд”** өдөрлөгийг Дархан-Уул аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, 5 өрхийн эрүүл мэндийн төв Дархан-50 цогцолборт, сумын эрүүл мэндийн төвүүд сумын хэмжээнд зохион байгуулж үйл ажиллагааны мэдээг цахимаар дамжуулсан. | 90% | Тийм | |

Боловсруулсан:

ХШҮМХ-ийн мэргэжилтэн С.Мөнхцэцэг